

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН
2024 ОНЫ 05 ДУГААР САРЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2024 оны 06 дугаар сарын 07

Улаанбаатар хот

Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн тус байгууллагад холбогдох зүйл, заалтуудын 2024 оны 01, 02 дугаар сарын хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ хийж, үр дүнг дараах байдлаар үнэлэв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээнд Засгийн газрын хуралдааны тэмдэглэлд тусгагдсан 2 арга хэмжээний 2 зүйл, заалтыг үйл ажиллагаандаа хамруулснаас нийт үнэлгээгээр 80 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдлээ. (Хүснэгт 1)

Хүснэгт 1

Шийдвэрийн төрөл			
Бүгд		Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	
Хяналтад авсан хууль, тогтоол шийдвэрийн тоо		2	2
Заалтын тоо		2	2
ҮНЭЛГЭЭ	Биелсэн /100%/	-	-
	Хэрэгжих шатанд /90%/	1	1
	Эрчимжүүлэх шаардлагатай /70%/	1	1
	Хугацаа болоогүй	-	-
Үнэлгээ /хувь/		80	

Шийдвэрийн төрөл тус бүрээр авч үзвэл Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээс “хэрэгжих шатандаа” буюу 90 хувь үнэлэгдсэн 1, “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 70 хувийн биелэлттэй 1 арга хэмжээ тус тус байна. Үүнд:

Арга хэмжээ-1: 4..Гадаад улсаас ирж буй иргэдийг хилээр нэвтрүүлэх үйлчилгээг технологийн дэвшлийг ашиглан шуурхай, нэг цэгийн үйл ажиллагаанд шилжүүлэх асуудлыг судлан танилцуулахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр нарт тус тус даалгав.” гэжээ

Хэрэгжилт: Гадаадын иргэн, харьяатын газар нь eimmigration.mn цахим бүртгэлийн системээр визийн зөвшөөрөл, визийн сунгалт, Монгол Улсад оршин суухтай холбоотой үйлчилгээ, цахим лавлагаа, гадаадын иргэний бүртгэлийг явуулж байна.

Гадаадын иргэнд бүртгэлийн дугаар олгох систем RNSF-ээр гадаадын иргэнд 13 орон бүхий бүртгэлийн дугаар (F-Register) олгож байна.

Түүнчлэн Wechat төлбөрийн үйлчилгээг хилийн боомт, evisa.mn, isf.mn системд тус тус нэвтрүүлж, төлбөр тооцоог хялбарчиллаа.

Мөн гадаадын иргэнийг орон байраар хангасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь 48 цагийн дотор гадаадын иргэнийг цахимаар бүртгүүлж байна.

Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан isf.mn системээр гадаадын иргэний 48 цагийн бүртгэл, виз, зөвшөөрөл, оршин суух зөвшөөрлийн хүсэлтийг хүлээн авч хянан шийдвэрлэж байна.

Цахим визийн evisa.mn системээр 99 улсын иргэнд визийг цахимаар олгож эхэлсэн бөгөөд Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 107 дугаар тогтоолоор бүх ангиллын визийг цахимаар олгож болохоор зохицуулсан.

Хилийн боомтод виз олгох үйлчилгээг түргэн шуурхай зохион байгуулах, хил дээр үүсэх ачааллыг бууруулах зорилгоор визийн мэдүүлгийн хуудсыг цахимаар бөглөх “Eform” программ хангамжийг шинээр хөгжүүлж, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн зэргээр гадаад улсаас ирж буй иргэдийг хилээр нэвтрүүлэх үйлчилгээг шуурхай хүргэж байна. (Хэрэгжилт 70 хувь)

Арга хэмжээ-2: 1.2.5.Иргэдийн зорчих нөхцөлийг хөнгөвчлөх талаар БНСУ-ын холбогдох байгууллагатай хэлэлцээ хийх үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулж, энэ хүрээнд дараах асуудлыг хэлэлцэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт:

-Монгол Улсын Засгийн газар болон БНСУ-ын Засгийн газар хооронд байгуулсан Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрт холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах замаар харилцан нийгмийн даатгалаас чөлөөлөх хугацааг нэмэгдүүлэх, төлөгдсөн нийгмийн даатгалын буцаан олголтод хамаарах визийн ангилал хүрээг нэмэгдүүлэх;

-БНСУ-д эмчилгээ хийлгэж буй иргэдийг дэмжих зорилгоор тус улсын эмнэлгүүдийн төлбөрийн хөнгөлөлтийг эдлүүлэх болон эрүүл мэндийн даатгалд хамрагдах; -Хөдөлмөрийн гэрээгээр БНСУ-д ажиллаж буй монгол иргэдийн эцэг, эх, үр хүүхэд, гэр бүлийн зүгээс тус улсад зорчих виз хүсэхэд тодорхой хөнгөлөлт эдлүүлэх.

Хэрэгжилт: Засгийн газрын 2023 оны “Монгол Улсын иргэдийн Бүгд Найрамдах Солонгос Улсад зорчих нөхцөлийг хөнгөвчлөх чиглэлээр авах арга хэмжээний тухай” 166 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Бүгд Найрамдах Солонгос Улсын Цагаачлалын албаны даргатай 12 дугаар сарын 15-ны өдөр, 01 дүгээр сарын 19-ний өдөр Сөүл хотноо тус тус албан уулзалт хийсэн. Уулзалтаар иргэд харилцан адил байх зарчмыг баримтлан Монгол Улсын иргэдийг хил нэвтрүүлэлгүй буцаахгүй байх, Бүгд Найрамдах Солонгос Улсын Хууль зүйн яамнаас хэрэгжүүлдэг өршөөлийн аянд хамруулан нутаг буцаах, тус улсыг сайн дураар орхин гарсан иргэнд дахин хууль ёсоор зорчих баталгааг гаргах, Монгол Улсад Бүгд Найрамдах Солонгос Улсын Цагаачлалын байгууллагын төлөөллийг томилуулан ажиллуулах зэрэг саналыг дэвшүүллээ. Мөн байгууллагын дарга Бүгд Найрамдах Солонгос Улсын Элчин зөвлөхтэй 02 дугаар сарын 22-ны өдөр уулзаж, тодорхой шаардлага хангасан болон олон удаагийн виз авах болзол хангасан иргэнд визийн хянан

шийдвэрлэх хугацааг богиносгож 7-14 хоногт багтаан шийдвэрлэж байх талаар хүсэлт гаргасан.

Улаанбаатар хотноо 05 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулагдсан Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын Гадаад харилцааны яамд хоорондын Консулын XI зөвлөлдөх уулзалтад байгууллагын дарга оролцож, тус улсад хууль ёсны дагуу зорчоод ирсэн иргэдэд олон удаагийн орох, гарах эрхтэй визийг олгох, Монгол Улсын төрийн дээд албан тушаалтан, үйл ажиллагаа нь тогтвортой аж ахуйн нэгжийн удирдлага болон тэдний гэр бүлийн гишүүд зэрэг олон удаагийн виз авах болзол хангасан иргэдэд виз олгох хугацааг богиносгох, хууль бусаар оршин суугаа иргэд сайн дураар нутаг буцсан тохиолдолд хилээр буцаж орох баталгааг гаргаж өгөх талаар саналыг дэвшүүлэв. (Хэрэгжилт 90 хувь)

Дүгнэлт, зөвлөмж

Гадаадын иргэн, харьяатын газрын 2024 оны 05 дугаар сарын Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол, шийдвэрт тусгагдсан 2 зорилт, арга хэмжээний хэрэгжилт 80 хувьтай үнэлэгдлээ.

Цаашид нийт арга хэмжээний үр дүнг бууруулахгүйгээр чанаржуулж, “хэрэгжих шатанд”, “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 90-70 хувьтай үнэлэгдсэн 2 арга хэмжээг эрчимжүүлж, “Eform” программ хангамжийг шинээр хөгжүүлж, үйл ажиллагаанд нэвтрүүлэн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллахыг зөвлөж байна.

--oo0oo--